

## ТЭНГЭРИЙН ИРГЭН – ТЭНГЭРЛЭГ НАЙРАГЧ ЛИ БАЙ (701-762)

### Т.СОДНОМЦОГ\*

Хятадын уран зохиолын түүхэнд Тан улсын үеийг “Яруу найргийн алтан үе” хэмээн тэмдэглэсэн байдаг. Учир нь хэмээвээс энэ үеийн яруу найргийн алтан үе Ли Бай, Дү Фү, Бай Зюй И, Ван Вэй зэрэг хятадын яруу найргийн сонгодог найрагчдыг төрүүлсэн үе гэдэг.

Тан улсын яруу найраг нь хэлбэр, урлахуй агуулга хийгээд сэтгэлгээний хувьд цоо шинэ дэвшилтэд үзэгдэл байлаа. Тэр үеийн яруу найраг бодит ахуй, эгэл хүмүүсийн бодол сэтгэлийг дүрслэн илэрхийлэхийг эрхэмлэн байв. Ван Вэй, Мэн Хаорань, Гао Ши, Ли Бай зэрэг найрагчдын уран бүтээлийн гол сэдэв нь эх орон ариун тансаг үзэсгэлэнт сайхныг дуулсан байгалийн уянга, найрагчийн байгаль ертөнцийг үзэх ухаарал, эрмэлзэл, хүслэнг дуулсан мөн эртний (хөөлөг) хүлэг баатарын гавъяат алдрыг магтан дуулсан дуулал шүлэгч, найрагч, эрдэмт мэргэдийн үерхэл нөхөрлөлийг дээдэлсэн хүмүүнлэгийн дуулал байлаа.

Ли Бай нь өнөөгийн Сычуань мужийн Зинь Жөү нутгийн унаган иргэн агаад Тан улсын дараах Чан Аныд (МЭ701) оны үед төрж, Тан улсын Сү Жөэбао-н үед (МЭ762) насан эцэслэжээ.

Тэрбээр баруун Ляо улсын эзэн хаан Ли Хаогийн 9 дахь үеийн ач ажээ. Харин түүний “Ли” хэмээх овгийг 4 настайдаа Сы Хуод аж төрж байгаад Хятад улсад нүүж ирэхэд нь эцэг нь өгсөн гэдэг. Тэрээр ганц Ли Бай хэмээх нэртэй байсангүй. Түүний амьдрал, алдар цуу, зан авир, шүлэг найргийг хэрхэн амьдарч байснаар нь ард түмэн нэр алдар хайрлаж байсан. Үүнд: Ли Бай (李白), Чан Тань (长庚), Чин Ляньжүту (青莲居士), Гүн Фен чаолин (供奉朝林), Зуй Шэн (醉圣), Жиү Сэнь (酒仙), Ши Сэнь (诗仙), Ли Хөү (李候), Лун Ши бү и (陇西布衣), Ли Тагүй (李拾

遗), Ли Ши эр (李十二), Жин Сү рүлай (金粟如来), Ли Дуншань (李东山) гэх зэрэг алдар нэртэй байжээ.

Нэгэн шөнө Чангэн од Ли Байн эхийн хэвлийд харван бууж, тийн жирэмслээд хэмээн зүүдэлж, тэрхүү одыг Тайбай хэмээн нэрийддэг тул хожим хүү мэндлэхэд мөнөөх одын нэрийг хайрласан гэдэг.

Дээрхи нэрээс нэгийг авч үзвэл: Ши Сэнь (诗仙) хэмээн нэрлэсний учиг Ли Бай нь Хятадын уран зохиолын түүхэн дэх агуу их романтизмын шүлэгч байсан. Тэрээр өмнөх үеийн романтизмын бүтээл амжилтыг залгамжилж авснаар үзэл санаа нь өөрчилж, өнгө аясыг омог төгөлдөр болгон феодалын дэглэмд дургүйцэж байснаар барахгүй романтизм болон реализмын уялдаа холбоог зохих түвшинд илэрхийлэн гаргаж чадсанаараа бусдад Ши Сэнь (诗仙) хэмээн нэрлэгджээ.

Тэрбээр эртний их хаадын түүх намтрыг нэвтэрхий судлан, Күнзийн сонгодог ном зохиол, эртний түүх уран зохиолыг гүнзгий судалж хэлж ярьсан нь цогц мэргэн, хурц ухаалаг тул ард олон түүнийг “Тэнгэрийн орны иргэн” хэмээн биширдэг байжээ. Мөн Күнзийн сургаальд нэвтэрсэн нэгэн байсан агаад, “Дао” хэмээх бумбын ёсны гүн ухааны мэдлэгт, Ушугийн байлдах урлагийг чадварлаг эзэмшсэн байлаа. Тэрбээр тийн авъяас билэг цогц нэгэн хэдий ч насан залуудаа бор дарсанд шимтэн орж, тэнгэрээс заяат авъяас билгээ хааны ордонд сууж шүлэг найрагаа тууривахын оронд хаана он удаан жил дарсан дарс байна түүнийг олж уун, онгод юугаан сэргээн шүлэг найргаа тэрлэн хөлчүүрэн байхыг илүүд үздэг нэгэн байв. Тийм ч учраас түүнийг Зуй Шэн (醉圣), Жиү Сэнь (酒仙) хэмээн нэрлэдэг байсан. Түүний дотны анд нангиад найргийн гэрэлт од найрагч Дү Фү

\*Т.Содномцог.МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн Хятад судлалын тэнхимийн 4-р дамжааны оюутан

шүлэглэхдээ:

Ганц гүц дарс л Ли Байд өгчих  
Гарцаагүй тэгвэл зуун шүлэг бичнэ.  
Чан Ань хотын зээл дээр харвуу  
Цаадах чинь архины мухлагт зүүрмэглэн  
сууна.

Эзэн хаан хойноос нь зарц илгээвч  
Эргэж оронд нь тэр очихгүй.  
Гон бие таны зарц билээ эзэнтэн минь  
Гэвч би согтуудаа тэнгэрийн иргэн.  
гэсэн байдаг.

Ийнхүү шүлэглэснийг үзвэл тэрээр амьдралынхаа ихэнх үеийг сархдад мансуурангаа онгодоо сэргээн шүлэг зохиолоо тэрэлдэг байсан нь “Сэлүүн шөний бодол”, “Саран доор гагцаар хөлчүүрмүй” зэрэг шүлэгт тодорхой харагдана.

Ли Бай 730 оны орчим Чан Аньд байхдаа улс төрийг сонгосон авч амжилт олоогүй, хэдий ч тэрээр хааны ивээлд багтаж, “Бийрийн аглаг” хэмээх эрдмийн хүрээлэнд орж, эзэн хаан, баатар жанжин, ноёд түшмэдийн гавъяат үйлсийг магтан мөнхрүүлэн шүлэглэн дуулах “Хүндтэй ажлыг” эрхэлдэг байжээ. Ийнхүү эдийн дээдийг эдэлж, амттаны дээдийг хүртэж байхдаа ч бор дарсанд мансуурсаар байсан гэдэг. 742 онд Чан Аньд дуудагдан ирж утга уран зохиол эрхэлсэн туслахаас сайд болон дэвшиж эх сурвалж бичих ажлыг хариуцах болсон байна. Энэ үед түүний шүлэг яруу найргийн авъяас онгод нь эд оргилж байсан. Гэвч жил гаруй болоод түүнд атаархагч бэртэгчин хүмүүсийн далд хорон явуулгаар ордноос хөөгдөн нийслэлээс явсан байна.

Тэрбээр хөвгүүн насандаа эцгийн гэрээс явж аглаг ууланд Бумбын ёсны арш нартай даяан хийж ном бясалган сууж байсан агаад улс төрийн байдлыг ихэд сонирхдог байжээ. Залуу зандан насандаа алдарт Эмэй уул, Юү мэн, Зулай уулнаа нөхдийн хамт даяанчлан Хятад орны үзэсгэлэнт нутгаар хөндлөн гулд аялахдаа байгалийн сайхныг бишрэн шүлэглэсэн нь: “Хан уулсын саран”, “Тэнгэрийн хаалга уулыг бараалахуй” зэрэг шүлэг илтгэж байна. 20 наснаасаа хойш Ли Бай нь Сы Жөү нутгаар, Хөх мөрөн, Шар мөрний дагуу 11 жил аялж эх орныхоо уул усыг хайрлах сэтгэлээ илрүүлэн нээж

чадсан төдийгүй тухайн үеийн улс төрийн хэрэг явдалд санаа зовж, хаан төрийн үйл хэрэгт оролцох эрхийг дахин олно хэмээн найдсаар байсан. Тэн Баогийн 3-р онд Ли Бай Дү Фүтэй хамт Лао янд танилцжээ. Тэн Баогийн 14-р онд их үймээн самуун дэгдэх үеэр Ли Бай одоогийн Анхуй мужид амьдарч байсан агаад 12-р сард албан ордонд залагдаж ирсэн байна. Юнь Ванг хорлогдоход Ли Бай мөн л ялд унаж одоогийн Зянь Сы мужийн Жү Жианд хоригдон төдөлгүй одоогийн Гүй Жөүгийн Тун Жи хэмээх газарт цөлөгдсөн байна. Энэ үед Ли Бай 59 настай байв. Ийнхүү хэрэн хэсч байхдаа бичсэн олон шүлэг байдаг. Тухайлбал:

### Сэлүүн шөнийн бодол

Орны өмнө туссан сарны туяаг хараад  
Огторгуйгаас буусан хяруу хэмээн

эндүүрвэй

Тэнгэрийн зүг өлийн гэгээн сарыг ширтээд  
Толгой гудайн төрсөн нутгаан санавай

Өтөл насаа Жан Ань орчмоор тэнүүчлэн өнгөрөөсөн гэдэг. Ли Бай нь Тан улсын үеийн чухал түүхэн үйл явдлын гэрч төдийгүй тухайн үеийн бодит байдлыг шүлэг яруу найрагтаа тод тусгасан байдаг. Ли Байн залуу нас Тан улсын үеийн феодалын эдийн засгийн хөгжил, улс төр нийгмийн байдал тогтворжсон, утга зохиол ялангуяа яруу найраг хурдацтай хөгжиж байх үед өнгөрсөн юм. Тэрбээр амьдралынхаа туршид улс төр, эх орныхоо үйл хэргийг анхаарч ирснийг түүний Гу Фэн (古风59 бадаг) шүлэг төлөөлдөг юм. Мөн улс төрийн ялзрал, хуурамч сайд түшмэдийг өөрийн шүлэг зохиолдоо хурцаар шүүмжилсэн агаад түүний шүлэг найргийн нилээд хувь нь эгэл ардын амьдралыг дүрсэлсэн байдаг. Мөн эмэгтэйчүүдийн амьдралын зовлон бэрхшээл, тариачин, загасчин, далайчин, уурхайчдын амьдрал, хөдөлмөрийн талбарыг шүлэглэн өгүүлсэн байдгийн сацуу түүний шүлгийн багагүй хувийг байгаль, ан амьтныг өрөвдөн хайрласан, байгалийн сайхныг яруу тодоор дүрсэлсэн шүлэг эзэлдэг байна. Хайр сэтгэл, янаг амраг, нөхөрлөлийн шүлэг найраг ч түүний бүтээлүүдэд онцгой байр эзэлдэг.

**Тэнгэрийн хаалга уулыг бараалахуй**  
Хөх мөрөн довтолгон ирж тэнгэрийн

хаалга нээгдмүй

Хөхөмдөг усан дорныг зорьсоор энд  
 цутган эргэлдмүй  
 Хоёр хөвөнд нь цэнхэр уулс  
 аниргүй ширтэлцэж  
 Хөлгийн дарвуул гагцаар, наран зүгээс  
 айсуй

Ли Байд бумбын шашны үзэл ихээр нөлөөлж түүний зохиол бүтээлд бумбын шашны үзэлд хүний ертөнцийг эрх чөлөөт амьдрал руу тэмүүлж буйг илэрхий тусгасан байдаг. Зарим судлаачид түүнийг ганц нэг шүлгээс нь Күнзийг эсэргүүцэгч, Күнзийг егөөддөг байсан гэж дүгнэдэг боловч Ли Бай нь Күнзийг ихэд хүндэлдэгээр барахгүй Күнзийн сурталыг шүлэг найрагтаа тод тусгадаг байв. Ли Байн шүлгийн түүхэнд эзлэх байр суурь нь ардын дуутай салшгүй холбоотой. Түүний “Хөгжмийн ордон” хэмээх шүлэг нь өмнөд хойд нутгийн ардын дуу юм. “Хөгжмийн ордон” шүлэг нь гүн ухагдахуунтай, уран дүрслэлтэй, эртний хөгжмийн өргөө мөн тэр үеийн нийгмийн байдал, онцлогыг маш тод тусгасан байдаг. Ли Бай өөрийн туурвисан олон шүлэгтээ бие бялдрын тухайд тодорхой хэмжээгээр өгүүлж, омог сүртэй, төгс төгөлдөр өнгө аястай байдаг нь: илдийн урлаг, нум сумаар ан хийх, морь унаж, ууланд авирах, аялах, завиар аялах, нудраган зодооноор удаан хичээлсэнтэй холбоотой. Энэ мэтээр биеийн тамирын төрлүүд түүний шүлэгт маш тодорхой туссан байдаг ч өнөөг хүртэл хүмүүсийн хүндэтгэлийг олоогүй аж. Тэрээр ордноос гараад олон газар, нутгаар удаан хугацаагаар аялж байхдаа хувийн орлогоо хэрхэн зохицуулж байсан нь бас их сонин. Түүний орлогын эх үүсвэр нь уран яруу шүлэг бичихэд оршиж байв. Хааны ордонд байхдаа хаан, баатар жанжин, ноёд түшмэдэд зориулж шүлэг тэрлэн, шагнал урамшуулал авч байсан боловч ордноос хөөгдөн зовж зүдрэх үедээ эгэл ардаас тусламж авч баярласан сэтгэлээ шүлгээр илэрхийлж хятад орноор хэрэн тэнүүчилж амь зуулгаа залгуулдаг байсан. Ли Байн үзэл

феодлын үеийн дээдсийн хүрээлэнд онцгой тусаж байсан шалтгаан нь хөрөнгө мөнгөтэй байсантай холбоотой ажээ.

Түүний шүлгийн онцлог нь голдуу 5 үсэгт 4 мөрөөр бичдэг байснаар ялгарна. Мөн хэтрүүлэл, амьдчлалын аргаар туурвидаг байсан агаад түүний шүлгийн үзэл санаа, утга агуулга нь туйлын гүнзгий, өнгө аяс нь омог төгөлдөр, хурц, яруу уянгалаг байдаг. Үүний зэрэгцээ Чу Юаний үзэл санаа зарим шүлэгт нөлөөлсөн ч бий.

Нэгэн шөнө мөрөнд завиар зугаалж явахдаа Ли Бай найрагч сархадаа хэтрүүлэн хөлчүүрхээд, усанд туссан сарны дүрсийг харан саран байна хэмээн андуурч түүнийг тэврэх гэж ус руу ухасхийн мөрөнд живж насан хутаг болсон гэдэг. Харин найрагч Ли Байг тэнгэрт халисан тухай ард олны дунд өнөөг хүртэл олон янзын домог яригдсаар иржээ.

Залуу насандаа Шу улсад байхдаа бичиж үлдээсэн шүлэг тун ховор байдаг. Өдгөө түүний 60 гаруй үргэлжилсэн үгийн зохиол 900 гаруй шүлэг найраг бидний үед уламжлагдаж, дэлхийн олон улс оронд орчуулагдан, хэвлэгдэж хүмүүний сонорыг мялаасаар байна.

Ли Байн шүлэг яруу найраг зохиолоос түүний зан авир их уянгалаг, омог төгөлдөр гэдгийг тодорхой харж болно. Тэрээр сайхан сэтгэлтэй, эх оронч, улс төр сонирхдог, түүнчлэн Хятад үндэстний түүхэн дэх аугаа яруу найрагч бөгөөд романтизмын яруу найрагчдийн төлөөлөгчийн нэг юм. Түүний алдар гавъяа, ач тусыг Хятадын уран зохиолын түүхэнд оруулсан агуу үйлсээр нь хэн хүнгүй мэдэх билээ. Түүний зохиол бүтээл зөвхөн хятадын утга зохиолд нөлөөлөөд зогсохгүй дэлхий утга зохиолыг баяжуулахад хувь нэмэр оруулсан хэмээн үздэг. Түүний бичсэн яруу шүлгийн ханз бичгийг Япон, Солонгосын ард түмэн аль эртнээс уншиж биширсээр иржээ. Учир нь дуудлага өөр ч дүрс үсгээр нэгэн утга гардагт учир нь оршиж байсантай холбоотой ажгуу.